



МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.1 дэх хэсэг, Гадаад харилцааны сайдын 2019 оны А/93 дугаар тушаалаар баталсан “Гадаад харилцааны яамны шагнал олгох журам”-ын 2.1.3 дахь хэсэг, Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/34 дүгээр тушаалаар баталсан “Гадаад харилцааны яам, хилийн чанадад ажиллаж буй Дипломат төлөөлөгчийн газрын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.1.1 дэх хэсэг болон Гадаад харилцааны сайдын зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Консулын алдар” өргөмжлөл олгох зааврыг 1 дүгээр хавсралтаар, “Консулын алдар” өргөмжлөлийн загварыг 2 дугаар хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын захирал /Б.Баярсайхан/, Төрийн захиргааны удирдлагын газрын захирал /С.Золжаргал/, Консулын газрын захирал /Л.Мөнхтүшиг/ нарт тус тус даалгасугай.

САЙД




Н.ЭНХТАЙВАН

Гадаад харилцааны сайдын  
2020 оны 12 сарын 31-ны өдрийн  
А/а.с. дугаар тушаалын хавсралт

“Консулын алдар” өргөмжлөл олгох заавар

1. Гадаад харилцааны яам, түүний системийн байгууллага, төрийн болон иргэдийн үүсгэл санаачилгын байгууллага, хуулийн этгээд, хувь хүн хилийн чанад дах монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах үйлсэд сэтгэл зүтгэл гарган томоохон хувь нэмэр оруулж, консулын чиглэлээр өндөр үр бүтээлтэй ажилласан консулын ажилтан, төрийн албан хаагч, иргэнд “Консулын алдар” өргөмжлөл олгоход энэхүү зааврыг мөрдөнө.
2. Консулын газар нь ГХЯ, ДТГ-уудын консулын асуудал хариуцсан ажилтнуудын тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайланг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүлээн авч, “Консулын алдар” өргөмжлөлд нэр дэвшүүлэх ажилтнууд болон консулын чиглэлээр өндөр үр бүтээлтэй ажилласан төрийн бусад байгууллага, иргэдийн үүсгэл санаачилгын байгууллага болон хуулийн этгээдийн ажилтан, албан хаагч, хувь хүний талаарх саналыг газрын нийт ажилтны зөвлөгөөнөөр хэлэлцэнэ. Иргэдийн үүсгэл санаачилгын байгууллагын ажилтан, албан хаагч, хувь хүнийг нэр дэвшүүлэхдээ холбогдох ДТГ-ын саналыг харгалзан үзнэ.
3. Консулын газар нь газрын нийт ажилтны зөвлөгөөнөөр асуудлыг хэлэлцэн протокол үйлдэж, тус яамны Ёс зүйн зөвлөлийн саналыг харгалзсаны үндсэн дээр шагналд нэр дэвшигчдийн материалыг Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн Гадаад харилцааны яамны дэргэдэх Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.
4. Төрийн захиргааны удирдлагын газар Төрийн албаны зөвлөлийн Гадаад харилцааны яамны дэргэдэх Салбар зөвлөлийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Гадаад харилцааны яамны удирдлагаар баталгаажуулж, Консулын газар, холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн нарт албан ёсоор уламжилна.
5. Жилд таваас долоо хүртэлх нэр дэвшигчийг тодруулж олгох бөгөөд хэрэв тухайн жилд консулын чиглэлээр онцгой ачаалалтай, үр бүтээлтэй ажилласан тохиолдолд өргөмжлөлд тодорхойлох нэр дэвшигчийн тоог хатуу хязгаарлахгүй.
6. “Консулын алдар” өргөмжлөлийг жил бүр Монгол Улсад орчин цагийн дипломат алба үүсч хөгжсөний ойг тохиолдуулан Гадаад харилцааны сайдын гарын үсэгтэй үнэмлэхийн хамт шагналын эзэнд гардуулж өгөх бөгөөд хэрэв өөрийн биеэр хүрэлцэн ирэх боломжгүй тохиолдолд Консулын газрын удирдлага, эсхүл холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнээр дамжуулан олгож болно.

Гадаад харилцааны сайдын  
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн  
08/65 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



Монгол Улсын Консулын алба  
Consular service of Mongolia